



VII/2022


Тархаасан: 2022 оны 8 дугаар сарын 12



## Үнэмлэхүй бага температур 2022 оны 7 дугаар сард Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд -4.0 °C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 7 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд +38.9°C, үнэмлэхүй бага температур Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд -4.0°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай<sup>1</sup> харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



<sup>1</sup> - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 7 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Хөвсгөл аймгийн Тариалан суманд 153.9 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Дундговь аймгийн Мандалговь, Мандах сумдад 31 м/с-д хүрсэн байна.


### Агаарын чанар

PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 7 дугаар сард Хайлааст, Мишээл экспо төв, Таван буудал, Амгалан, Богд хааны ордон музей, Баруун дөрвөн зам, 13-р хороолол, Нисэх, Тахилт, Ургах наран хороолол, Цахилгаан станц, Баянхошуу, Зуун айл, Толгойт, Зурагт орчимд 0.046 мг/м<sup>3</sup>-0.244 мг/м<sup>3</sup>-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.036мг/м<sup>3</sup>-0.234мг/м<sup>3</sup>-ээр буюу 4.6-24.4 дахин давсан байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 7 дугаар сард Баруун дөрвөн зам орчимд 0.062 мг/м<sup>3</sup>-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.012 мг/м<sup>3</sup>-ээр буюу 24.0 хувиар давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 10 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.007 мг/м<sup>3</sup> (14.9%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж агууламж 0.004 мг/м<sup>3</sup> (37.7%)-ээр, азотын давхар ислийн дундаж 0.001 мг/м<sup>3</sup> (3.3%)-ээр тус тус бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, мг/м<sup>3</sup>



### Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 7 сарын байдлаар 2602 болж, өмнөх оны мөн үеэс 291 (12.6%) -ээр өссөн байна. Газар хөдлөлт 2022 оны эхний 7 сарын байдлаар 39 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 216 (84.7 %) -гаар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 7 сарын байдлаар нийт 165 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 7 (4.1%) -гоор буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 7 сарын байдлаар 11.1 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГ ДЭЛ, ОСОЛ<sup>2</sup>, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-VII	2020 I-VII	2021 I-VII	2022 I-VII	<u>2022 I-VII</u>
					<u>2021 I-VII</u>
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	3 403	2 760	2 311	2 602	112.6
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	22	32	255	39	15.3
Объектын түймрийн тоо	2 885	2 079	1 521	1 944	127.8
Амь насаа алдсан хүний тоо	146	161	172	165	95.9
Учирсан хохирол, тэрбум төгрөг	30.8	107.8	16.2	11.1	68.5
Зарцуулсан зардал, сая төгрөг	1 056.2	178.9	1 032.3	2 178.7	2.1 <sup>1</sup>

<sup>2</sup> - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

### Ойлголт, тодорхойлолт:

**Агаарын бохирдол:** Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

**Аюулт үзэгдэл:** Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

**Гамшиг:** Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

**Зөвшөөрөгдөх түвшин:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

**Хүлцэх агууламж:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



### Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар;  
Онцгой байдлын ерөнхий газар;

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 9 дүгээр сарын 14

Эдийн засгийн статистикийн  
газрын дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн  
газрын ахлах статистикч Б.Уянгаа  
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212